



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/27/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр	
	Утас: 70483413	Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
	Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг	
	Утас: 70484055	Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
	Ахлах аудитор: Ж.Бүжинханд	
	Утас: 99177546	Цахим хаяг: Bujinkhandj@audit.gov.mn
	Аудитор Г.Энхдэлгэр	
	Утас: 70484030	Цахим хаяг: Enkhdelgerg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
4. Аудитын илрүүлэлт	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.03.04 № 156

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Говь-Алтай аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлалгүйгээр тавилга бэлтгэсэн, хамтын сангийн хуримтлалд зориулж ажилчдын цалингаас суутгал хийсэн, татварын тодорхойлолтоор зөрүү тооцоо татварын цахим системд бүртгэлтэй, татварын болон нийгмийн даатгалын тайланд ажилчдын цалин хөлсний орлогыг зөрүүтэй тайлагнасан, хувь хүний орлогын албан татварын өр үүсгэсэн, нягтлан бодох бүртгэлийг алдаатай бүртгэсэн зэрэг 65.5 сая төгрөгийн зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 27.1, Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

07030407

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР / Х.ТҮВШИНБАЯР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	68,789,198.40	69,474,638.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	7,543,461.60	16,870,830.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	7,543,461.60	16,870,830.00
35	БАРАА МАТЕРИАЛ	61,245,736.80	52,603,808.00
35400	Хангамжийн материал	61,245,736.80	52,603,808.00
35410	Бичиг хэргийн материал	6,905,994.00	5,715,994.00
35420	Аж ахуйн материал	32,394,945.00	24,524,897.00
35430	Сэлбэг хэрэгсэл	81,000.00	484,000.00
35440	Түлш, шатах тослох материал	113,880.80	-
35450	Барилгын засварын материал	1,894,700.00	2,723,700.00
35460	Хүнсний материал	344,650.00	344,650.00
35470	Бусад хангамжийн материал	19,510,567.00	18,810,567.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,083,848,836.64	3,120,505,001.04
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,083,848,836.64	3,120,505,001.04
39200	Биет хөрөнгө	3,043,848,836.64	3,077,580,001.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,031,073,224.77	3,031,073,224.77
39202	Хуримтлагдсан элэгдэл	(191,100,520.85)	(263,078,592.65)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	23,500,000.00	23,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(6,527,777.60)	(10,444,444.16)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	261,879,382.68	229,757,263.92
39206	Хуримтлагдсан элэгдэл	(194,912,698.74)	(76,324,873.93)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	194,795,286.67	188,905,965.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(96,415,396.97)	(66,927,277.68)
39214	Бусад үндсэн хөрөнгө	38,864,272.00	36,225,122.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(17,306,935.32)	(15,106,386.23)
39300	Биет бус хөрөнгө	40,000,000.00	42,925,000.00
39301	Програм хангамж	5,850,000.00	2,925,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5,850,000.00)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	40,000,000.00	40,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,152,638,035.04	3,189,979,639.04
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	9,643,112.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	9,643,112.00
41300	Өглөг	-	9,643,112.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	9,643,112.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,152,638,035.04	3,180,336,527.04
51	Засгийн газрын хувь оролцоо	3,152,638,035.04	3,180,336,527.04
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	77,936,717.82	77,936,717.82
51200	Хуримтлагдсан үр дүн	2,838,170,220.21	2,865,868,712.21
51210	Өмнөх үеийн үр дүн	2,938,178,920.73	2,838,170,220.21
51220	Тайлант үеийн үр дүн	(100,008,700.52)	27,698,492.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	236,531,097.01	236,531,097.01
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,152,638,035.04	3,189,979,639.04

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	806,171,545.00	933,058,528.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,712,325.00	122,397,539.00
120	Нийтлэг татварын бус орлого	11,712,325.00	122,397,539.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,712,325.00	122,397,539.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	165,464.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	11,546,861.00	122,397,539.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	794,459,220.00	810,660,989.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	434,768,200.00	419,531,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	434,768,200.00	419,531,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	70,653,820.00	98,389,289.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив	44,441,320.00	39,420,600.00
131103	ЗГНХ,ЗДНХ-хөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс	8,512,500.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод	17,700,000.00	33,650,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон	-	25,318,689.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	289,037,200.00	292,740,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	289,037,200.00	292,740,500.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	906,180,245.52	905,360,036.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	906,180,245.52	905,360,036.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	837,703,260.88	869,543,582.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	265,864,620.10	273,037,551.60
210101	Үндсэн цалин	209,328,887.75	216,093,604.60
210102	Нэмэгдэл	43,987,732.35	43,387,316.00
210103	Унаа хосолны хөнгөлөлт	12,548,000.00	13,084,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	472,631.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,616,363.16	34,859,183.99
210201	Тэтгэврийн даатгал	22,639,446.35	24,229,026.18
210202	Тэтгэмжийн даатгал	2,715,193.00	2,784,181.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,075,194.40	2,187,025.43
210204	Ажилгүйдлийн даатгал	468,202.67	514,450.05
210205	Эрүүл мэндийн даатгал	4,718,326.74	5,144,500.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	280,372,051.00	281,923,914.00
210301	Гэрэл, цахилгаан	6,422,967.00	7,253,064.00
210302	Түлц халаалт	269,653,436.00	271,521,600.00
210303	Цэвэр, бохир ус	4,295,648.00	3,149,250.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,080,240.00	22,620,335.80
210401	Бичиг хэрэг	4,737,850.00	12,092,325.00
210402	Тээвэр, шатахуун	8,062,900.00	5,176,780.80
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,073,440.00	3,695,730.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,899,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,307,050.00	1,535,500.00
2105	Нормативт зардал	9,194,000.00	12,018,900.00
210502	Хоол, хүнс	9,194,000.00	12,018,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	359,400.00	35,346,889.03
210601	Багаж, техник, хэрэгсэл	150,000.00	5,816,788.06
210602	Тавилга	-	31,166.97
210604	Урсгал засвар	209,400.00	29,498,934.00
2107	Томилголт, зочны зардал	21,598,520.00	19,536,400.00
210702	Дот оод албан томилголт	21,598,520.00	19,536,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	50,708,734.00	37,502,454.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	49,286,410.00	36,134,610.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	37,584.00	39,844.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,500.00	30,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,090,000.00	905,000.00
210807	Газрын төлбөр	61,240.00	193,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	157,909,332.62	152,697,953.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,663,377.00	37,649,132.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,757,300.00	3,896,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	142,488,655.62	111,152,321.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,476,984.64	35,816,454.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,104,200.00	34,007,600.00
213207	Тэтгээрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	34,815,000.00	32,047,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,289,200.00	1,960,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	6,573.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	6,573.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас,	12,116,596.00	121,686.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,665,149.00	121,686.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,451,447.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,256,188.64	1,680,595.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,256,188.64	1,680,595.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (II)=(I)-(II)	(100,008,700.52)	27,698,492.00
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(II)-(IV)-(V)	(100,008,700.52)	27,698,492.00
VI-I	Засгийн газрын хувь оролцоо	-	-
VI-II	Хяналтын бус хувь оролцоо	-	-

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	77,936,717.82	236,531,097.01	2,938,178,920.73	3,252,646,735.56
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	77,936,717.82	236,531,097.01	2,938,178,920.73	3,252,646,735.56
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(100,008,700.52)	(100,008,700.52)
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	77,936,717.82	236,531,097.01	2,838,170,220.21	3,152,638,035.04
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	77,936,717.82	236,531,097.01	2,838,170,220.21	3,152,638,035.04
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	77,936,717.82	236,531,097.01	2,838,170,220.21	3,152,638,035.04
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	27,698,492.00	27,698,492.00
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	77,936,717.82	236,531,097.01	2,865,868,712.21	3,180,336,527.04

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	794,624,684.00	810,660,989.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	794,624,684.00	810,660,989.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	434,768,200.00	419,531,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	434,768,200.00	419,531,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	70,819,284.00	98,389,289.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	44,441,320.00	39,420,600.00
131103	ЭГНХЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,512,500.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,700,000.00	33,650,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	165,464.00	25,318,689.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	289,037,200.00	292,740,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	289,037,200.00	292,740,500.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	774,734,384.00	779,402,089.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	774,734,384.00	779,402,089.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	706,257,399.36	743,585,635.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	272,497,351.20	274,477,196.00
210101	Үндсэн цалин	174,554,596.15	165,192,339.00
210102	Нэмэгдэл	31,525,945.60	38,080,226.00
210103	Унаа жолны хөнгөлөлт	12,788,999.45	10,074,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	53,627,810.00	61,130,631.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шилжэл	32,451,796.16	33,103,798.00
210201	Тэтгэврийн даатгал	28,998,181.79	22,510,599.83
210202	Тэтгэмжийн даатгал	1,150,768.21	2,648,299.56
210203	УОМШӨ-ний даатгал	685,414.68	2,118,599.48
210204	Ажилгүйдлийн даатгал	217,368.12	529,699.53
210205	Эрүүл мэндийн даатгал	1,400,063.36	5,296,599.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	280,372,051.00	281,923,914.00
210301	Гэрээ, цахилгаан	6,422,967.00	7,253,064.00
210302	Түлш, жалаалт	269,653,436.00	271,521,600.00
210303	Цэвэр, бохир ус	4,295,648.00	3,149,250.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,269,270.00	21,184,261.00
210401	Бичиг хэрэг	5,212,850.00	10,527,325.00
210402	Тээвэр, шатахуун	8,176,780.00	5,062,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,073,440.00	3,695,730.00
210405	Хог хаягдал зайлуулах, жортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,806,200.00	1,778,306.00
2105	Нормлигт зардал	9,194,000.00	12,018,900.00
210502	Хол, хүнс	9,194,000.00	12,018,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	444,000.00	22,040,180.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	444,000.00	-
210604	Урсгал засвар	-	22,040,180.00
2107	Томилголт, зочны зардал	21,598,520.00	19,536,400.00
210702	Дотоод албан томилолт	21,598,520.00	19,536,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,058,734.00	37,647,854.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	50,636,410.00	36,280,010.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	37,584.00	39,844.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,500.00	30,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,090,000.00	905,000.00
210807	Газрын төлбөр	61,240.00	193,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,371,677.00	41,653,132.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,614,377.00	37,984,132.00
210902	Хичээл үйлдвэрлэлтийн дадлага хөлийх	6,757,300.00	3,669,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,476,984.64	35,816,454.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,104,200.00	34,007,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	34,815,000.00	32,047,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,289,200.00	1,960,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	6,573.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлж шилжүүлэг	-	6,573.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	12,116,596.00	121,686.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,665,149.00	121,686.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,451,447.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,256,188.64	1,680,595.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,256,188.64	1,680,595.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	19,890,300.00	31,258,900.00
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	19,890,300.00	31,258,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,890,300.00	31,258,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	19,890,300.00	31,258,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	19,890,300.00	31,258,900.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(19,890,300.00)	(31,258,900.00)
VII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)=(III)+(VI)+(V)	-	-
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Цэвэр гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	712,271,700.0	710,469,419.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	712,271,700.0	710,469,419.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	678,174,100.0	676,461,819.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	264,830,000.0	264,829,975.00
210101	Үндсэн цалин	168,351,000.0	155,017,749.00
210102	Нэмэгдэл	42,831,700.0	38,080,226.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	10,074,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	53,647,300.0	61,658,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,103,800.0	33,103,798.00
210201	Тэтгэврийн даатгал	22,510,600.0	22,510,599.83
210202	Тэтгэмжийн даатгал	2,648,300.0	2,648,299.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,118,600.0	2,118,599.48
210204	Ажилгүйдлийн даатгал	529,700.0	529,699.53
210205	Эрүүл мэндийн даатгал	5,296,600.0	5,296,599.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	282,041,800.0	281,923,914.00
210301	Гэрэл, цахилгаан	7,370,200.0	7,253,064.00
210302	Түлш, халаалт	271,521,600.0	271,521,600.00
210303	Цэвэр, бохир ус	3,150,000.0	3,149,250.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,008,600.0	7,811,756.00
210401	Бичиг хэрэг	1,475,000.0	1,474,750.00
210402	Тээвэр, шатахуун	2,147,100.0	2,146,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,400,000.0	2,400,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариут	240,000.0	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,746,500.0	1,670,506.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,740,000.0	41,953,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,041,300.0	17,634,900.00
210602	Тавилга	14,000,000.0	13,624,000.00
210604	Урсгал засвар	10,698,700.0	10,694,900.00
2107	Томилолт, зочны зардал	2,000,000.0	1,871,600.00
210702	Дотоод албан томилолт	2,000,000.0	1,871,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хур	3,658,400.0	3,313,844.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,000,000.0	1,946,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.0	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	40,000.0	39,844.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	45,000.0	30,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,179,900.0	905,000.00
210807	Газрын төлбөр	193,500.0	193,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,791,500.0	41,653,132.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,023,300.0	37,984,132.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,768,200.0	3,669,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,097,600.00	34,007,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,097,600.0	34,007,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	32,047,600.0	32,047,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,050,000.0	1,960,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	712,271,700.0	710,469,419.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	419,531,200.0	417,850,605.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	419,531,200.0	417,850,605.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	292,740,500.0	292,618,814.00
132001	Орон нутгийн төсвөөс	292,740,500.0	292,618,814.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	98,389,289.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	98,389,289.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	98,382,716.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	9,647,221.00
210101	Үндсэн цалин		9,647,221.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	13,437,505.00
210401	Бичиг хэрэг		9,052,575.00
210402	Тээвэр, шат ахуун		2,916,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		1,295,730.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		172,800.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
2105	Нормативт зардал	-	12,018,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
210502	Хоол, хүнс		12,018,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	11,280,280.00
210604	Урсгал засвар		11,280,280.00
2107	Томилолт, зочны зардал	-	17,664,800.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт		17,664,800.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	34,334,010.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		34,334,010.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	6,573.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	6,573.00
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг-Нэмэлт санхүүжилт		6,573.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	98,389,289.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	98,389,289.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	39,420,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	33,650,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	25,318,689.00
131106	Төсвийн урамшуулал	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Энхдэлгэр гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2021 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 30 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говь-Алтай аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь "Гэр бүл, хүүхэд, залуучуудад сурч хөгжих амьдрах ээлтэй орчныг бүрдүүлж иргэн бүрийн хэрэгцээнд тулгуурласан арга хэмжээг зохион байгуулан хөгжил оролцоог эрхэмлэж хамгааллын үйлчилгээг үзүүлэх" эрхэм зорилгын дор үйл ажиллагаагаа эрхлэн гүйцэтгэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна. Нягтлан бодох бүртгэлийг алдаатай хөтөлдөг, ажилчдад болон нягтлан бодогч өөртөө их хэмжээний урьдчилгаа авч цалингаас суутгадаггүй асуудлуудыг илрүүлээгүй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн зардлын 694.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 13.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 11.1 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн зардлын 916.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 18.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 14.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 37.3 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн данс байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 52.6 сая төгрөг болж 8.6 сая төгрөгөөр буурсан нь аж ахуйн материалын зарцуулалт өссөнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 42.8 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 51.4 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 52.6 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,552.4 сая төгрөг болж 43.6 сая төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 31.3 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 122.4 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсантай холбоотой байна. Тайлант онд 31.7 сая төгрөгийн хөрөнгийг акталсан ба тайлант оны эцэст 3,552.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Өглөг дансны үлдэгдэлд ХХОАТ-ын 9.6 сая төгрөгийн өглөг бүртгэлтэй байна.

Авлагын дансны үлдэгдэлд хувь хүнээс авах 16.9 сая төгрөгийн авлагатай байсныг аудитын явцад бүрэн төлүүлсэн.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,163.5 сая төгрөг болж 10.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү 6.1 сая төгрөгийн авлага хаасан бичилт хийгдсэн ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 2,849.0 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 712.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 4 арга хэмжээг тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжүүлэхээр 419.5 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 292.7 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 419.5 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 292.7 санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 710.5 сая төгрөгийг зарцуулж 1.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 710.5 сая төгрөг буюу 99.7 хувьтай байна. Зардал хэмнээгүй.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 98.4 сая төгрөгийн санхүүжилт орж, урсгал зардалд 98.4 сая төгрөг зарцуулж тайлагнасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Төрийн албаны зөвлөлийн хийсэн хяналт шалгалтаар Төрийн албаны тухай хууль тогтоомж зөрчиж томилсон 4 албан тушаалтан ажиллаж байна. Төрийн албаны зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлж, хууль тогтоомж зөрчиж томилгоо хийхгүй байх.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 150 мэдээллээс 106 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон 44 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан

дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ. 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2.3 сая төгрөгийн төлбөрийн акт, 13.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 12.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж, 1 сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна. Цалингийн урьдчилгаа олгоод суутгадаггүй зөрчлийг давтан гаргасан боловч аудитын явцад зөрчлийг арилгаж төлүүлсэн.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар төсвийн хэмнэлтийн горимыг баримталж ажиллаж буй эсэхийг, мөн тээвэр шатахууны зарцуулалт, норм, бараа материалын тулгалт, цалингийн тооцоолол, нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг дансдаар үзэх нь зүйтэй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 88.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 23.3 сая төгрөгийн алдааг залруулж, 65.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, мөн 1 сахилгын шийтгэл оногдуулах албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад санхүүгийн тайланд 6.5 сая төгрөгийн залруулга хийж, урьдчилгаа олгоод суутгаагүй 16.9 сая төгрөгийг аудитын явцад төлүүлсэн.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

4.3 Албан шаардлага

Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлалгүйгээр 13.6 сая төгрөгөөр тавилга бэлтгэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалт "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тодорхойлолтоор 1.8 сая төгрөгийн зөрүү тооцоо татварын цахим системд бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Хувь хүний орлогын албан татварын 9.6 сая төгрөгийн өглөг үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тайланд цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг 3.0 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д "Суутган төлөгч энэ хуулийн 14 дүгээр зүйл, 16.1.2, 16.1.3, 16.1.4, 17.1.1, 18 дугаар зүйл, 19.1.1, 19.1.2, 20.1-д заасны дагуу тодорхойлсон орлогод ногдуулан суутгасан албан татварын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ" нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Хамтын сангийн хуримтлалд зориулж ажилчдын цалингаас 1.2 сая төгрөгийг суутгасан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1-т "Ажил олгогч ажилтны цалин хөлсийг бүрэн хэмжээгээр нь олгох бөгөөд дараах тохиолдолд суутгал хийж болно:" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Нийгмийн даатгалын тайланд 2 ажилтны цалинг 1.6 сая төгрөгөөр дутуу тайлагнасан нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт "Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ: 1/хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх;" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн актаар нэхэмжилсэн, төлсөн дүн таарсан хэдий ч 23.1 сая төгрөгийн тогтмол зардлыг шууд зардлаар тайлагнасан, суутгаагүй 1.8 сая төгрөгийн цалингийн урьдчилгааг авлага үүсгээгүй, багаж техник хэрэгслээс авсан 6.5 сая төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгөнд орлого авсан хэдий ч тооцоо үүсгэлгүй шууд зардлаар бичилт хийж бүртгэлийн алдаа гаргасан, бичиг хэргийн 3.2 сая төгрөгийн материалыг бүртгэлд орлого авч зарлага гаргалгүйгээр зөвхөн шаардах хуудсыг үндэслэн шууд зардлаар тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр", УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтний нийцэхгүй бөгөөд толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Тайлант хугацаанд нягтлан бодогч нь өөртөө авсан урьдчилгаанаас 10.8 сая төгрөгийг дутуу суутгасан, өмнөх онд үүсгэсэн нягтлан бодогч болон ажилчдаас суутгах 6,072.6 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, зөрчлийг давтан гаргасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул сахилгын шийтгэл оногдуулах албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар илэрсэн зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд аудитын шийдвэрийн хэрэгжилтийг мэдээлээгүй.
- 1.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.

2. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Говь-Алтай аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	12	88.9	2	23.3			9	65.6	1	0